

Шивээговь сумын ЗДТГ-ын дарга

Батлав: Д.Отгонжаргал

Огноо: 2019 он 01 сарын 10



**ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ  
ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР СОНГОН ШАЛГАРУУЛАХ,  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ ХҮНСНИЙ  
ДЭЛГҮҮР СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
Төслийн дугаар: 2018-ХА-01

Говьсүмбэр аймаг, Шивээговь сум

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Говьсүмбэр аймаг Шивээговь сум нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх хүнсний дэлгүүр”**-ийг сонгон шалгаруулах бараа нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019** оны **01** сарын **17**-ний өдрийн **14** цаг **00** минут хүртэл Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Нутгийн удирдлагын ордон 2 давхар 207 тоот өрөө Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Шивээговь сум хариуцсан мэргэжилтэн Б.Базаррагчаа Утас: 99711038 хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019** оны **01** сарын **17**-ний өдрийн **14** цаг **10** минутад нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Нутгийн удирдлагын ордон 2 давхар  
207 тоот өрөө Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний  
газрын Шивээговь сум хариуцсан мэргэжилтэн Б.Базаррагчаа Утас:  
99711038

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болоо нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл / 2016 оны санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Туршлагын мэдээлэл /Сүүлийн 5 жил худалдаа үйлчилгээний чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулсан байх/</li> <li>2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар               <ol style="list-style-type: none"> <li>1. Харилцагч банкны тодорхойлолт</li> <li>2. Татварын албаны тодорхойлолт</li> <li>3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> </ol> </li> <li>4. Хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулах чиглэлээр Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлсэн бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>5. Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар</li> <li>6. Дэлгүүрийн давуу талыг харуулсан танилцуулга болон бусад мэдээлэл</li> </ol> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Жин хэмжүүр-1, баталгаажсан байх</li> <li>2. Хөргөгч, хөлдөөгч - зориулалтын байх</li> <li>3. Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх ачааны машин-1, <i>/Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын шаардлага хангасан байх/</i></li> <li>4. Зоорь, агуулах –стандартын шаардлага хангасан байх <i>/Эдгээрийн гэрчилгээний хуулбар, зураг зэргийг ирүүлж нотолно./</i></li> <li>5. Агуулах байрны гэрчилгээний хуулбар, түрээслэх бол 2019 оны түрээсийн гэрээг ирүүлэх</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, Нутгийн удирдлагын ордон</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхар 207 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 01 сарын 17-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, Нутгийн удирдлагын ордон</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхар 207 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 01 сарын 17-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 10 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь техникийн тодорхойлолтод заасан нэр бүхий багцуудаас бүрдэнэ.</p>

## **БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ Нийлүүлэлтийн хуваарийн дагуу тендерт оролцогч саналаа боловсруулж ирүүлнэ.
2. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ
3. Техникийн тодорхойлолт
4. Дэлгүүрүүд нь ХЭБ-ийн үйлчилгээний чиглэлээр ижил загварын мэдээллийн самбар, санал хүсэлтийн дэвтэр байршуулна.
  - Дэлгүүрүүд цахим хэлбэрийн үйлчилгээ үзүүлэх боломжтой, карт уншигч машин суурилуулах нөхцөл бүрдсэн, кассын машин, харилцагч банкны ПОС машин байршуулсан байна. /Төрийн банкны поссын машинтай байх/
  - Үйлчилгээний зай талбай тохирох хэмжээнд байх ба нэгэн зэрэг олон үйлчлүүлэгчидтэй ажиллах боломжтой байна.
  - Гэрээ байгуулж ажиллах дэлгүүрийн байршил үйлчилгээ хүртэгч иргэдэд ойр тухайн багт байрлалтай байх шаардлагатай бөгөөд хүнсний эрхийн бичгээр олголтын үед ачаалал даах чадвартай байвал зохино.
  - Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрт "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-д заасан 10 нэр төрлийн бүтээгдэхүүн заавал байх шаардлагатай бөгөөд дээрх бүтээгдэхүүнүүд олон сонголттой байвал зохино.
  - 10 нэр төрлийн бүтээгдэхүүнээс бусад согтууруулах, мансууруулах гэх мэт хүнсний бус бүтээгдэхүүнийг олгохгүй байх.
  - Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэнд зориулсан бараа нь хямд үнэтэй чанаргүй, барааны хадгалалт хамгаалалт болон тээвэрлэлтийн горим алдагдсан бус, эрүүл ахуй, стандартын шаардлагыг хангасан байвал зохино.
  - Барааны сав баглаа боодол бүрэн бүтэн байх
  - Талоноор олгогдож байгаа хүнсний бүтээгдэхүүн нь тухайн зах зээлийн дундаж үнэ болон дэлгүүрийн тендерт оролцохоор санал ирүүлсэн үнэтэй ижил үнээр олгогдоно.
  - Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх өрхийн тоо нэг дэлгүүрт дээд хязгаар нь 80 өрх байхаар тооцно.

## ТУСГАЙ ШААРДЛАГА:

1. Бүтээгдэхүүнийг сар бүр цаг алдалгүй нийлүүлж байх.
2. Шаардлагад нийцээгүй бүтээгдэхүүнийг буцаах ба түүнээс үүсэх хохирлыг нийлүүлэгч тал өөрөө хариуцна.
3. Өөрийн бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийг /шаардлагатай бол тухай бүр/ улирал бүрийн эхэнд ХХҮГ-т өгч байх.

### Хүнсний эрхийн бичгээр олгох бүтээгдэхүүний жагсаалт

*/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 сарын 21-ний өдрийн А/13 дугаар тушаалын 3 дугаар хавсралт/*

№	Бүтээгдэхүүний нэр	
1	<b>Мах, дайвар бүтээгдэхүүн /Импортын бус/</b> Хиам болон лаазалсан, лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн орохгүй.	Хонины мах 1-р зэрэг
		Ямааны мах 1-р зэрэг
		Адууны мах 1-р зэрэг
		Дайвар махан бүтээгдэхүүн /гэдэс дотор, толгой, шийр/
2	<b>Сүү, сүүн бүтээгдэхүүн /Импортын бус/</b>	Литрийн сүү
		Савалгаатай сүү
		Савалгаатай тараг
		Ааруул
		Аарц
3	<b>Гурил, гурилан бүтээгдэхүүн /Импортын бус/</b> Бялуу, кекс хамаарахгүй.	1-р гурил /25 кг Улаанбаатар гурилтай дүйцэхүйц/
		1-р гурил /25кг Алтан тариа гурилтай дүйцэхүйц
		Туузан гоймон
4	<b>Цөцгийн тос</b>	Шар тос
		Цагаан тос
5	<b>Элсэн чихэр</b>	
6	<b>Төмс, хүнсний ногоо</b> Дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн орохгүй.	Төмс
		Байцаа
		Манжин
		Лууван
		Сонгино
7	<b>Будаа</b> Хүүхдийн будаа, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна.	Цагаан будаа
		Гурвалжин будаа
		Шар будаа
8	<b>Ургамлын тос</b>	
9	<b>Өндөг</b>	
10	<b>Жимс, жимсгэнэ</b> Компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй.	Алим /Польш/
		Мандарин /жижиг/
		Мандарин /том/

	Помидор /жижиг/
	Чацаргана

### ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. "Мах, дайвар бүтээгдэхүүн"- д тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 1

№	Мах, дайвар бүтээгдэхүүн нь дараах стандартын шаардлагыг хангасан байна.	
	Мах, махан бүтээгдэхүүн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага	MNS 5023:2001
	Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага	MNS1111-2007
	Хүнсний зориулалттай дотор мах, дайвар түүхий эд болон тэдгээрийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага	MNS 1023:2007
	<p align="center"><b>Стандартын шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Мал эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй, халдварт болон паразитлах өвчнөөр өвчлөөгүй, тайван нутгаас бэлтгэгдсэн болох нь мал эмнэлгийн байгууллагаар баталгаажсан мал, амьтдыг хүлээн авна.</li> <li>➢ Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байх</li> <li>➢ Өнгө, үзэмж сайтай байх /зөвхөн мах 1,2 – зэрэг/</li> <li>➢ Хүнсний бүтээгдэхүүн стандартад нийцсэн байх</li> <li>➢ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна.</li> <li>➢ Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх</li> <li>➢ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх</li> <li>➢ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх</li> <li>➢ Махан бүтээгдэхүүн туслан гүйцэтгэгчтэй байж болох ба туслан гүйцэтгэгч нь дээрх шаардлагыг хангасан байна.</li> </ul>	

2. "Сүү, сүүн бүтээгдэхүүн"-д тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 2

№	Сүү, сүүн бүтээгдэхүүний нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Малын түүхий сүү Ундны сүү	MNS 4228:2011 MNS 0219:2011
2	Уураг цагаан идээ /Аарц, ааруул, эзгий/	MNS 4230:2005
3	Тараг	MNS 21508 MNS 2152:1983
	<p align="center"><b>Стандартын шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Мал амьтны гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, бусад дагалдах баримт бичигтэй байх.</li> <li>➢ Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байх</li> <li>➢ Нэр төрөлдөө тохирсон, өнгө, үзэмж сайтай байх</li> <li>➢ Бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх</li> <li>➢ Бүтээгдэхүүнийг нян, бичил биетэн нэвтрэн орох, бохирдох, гэмтэхээс сэргийлсэн шаардлага хангасан нөхцөлд хадгалж, зориулалтын хэрэгслээр тээвэрлэх.</li> <li>➢ Агуулах нь орчны дулааны хэм, чийглэг, зэрэг хадгалалтын горимыг хангах, хянах, зохицуулах боломжтой байх.</li> </ul>	

### 3."Гурил, гурилан бүтээгдэхүүн"-д тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 3

№	Гурил, гурилан бүтээгдэхүүний нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Буудайн гурил	MNS 244:2009
2	Гоймон	MNS
<p align="center"><b>Стандартын шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Нэр төрөлдөө тохирсон, исгэлэн буюу гадны ямар нэгэн амт үнэргүй байна.</li> <li>➤ Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байна.</li> <li>➤ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх</li> <li>➤ Агаарын харьцангуй чийглэгтэй, цэвэр хуурай, энгийн гэрэлтүүлэгтэй, агааржуулалт сайтай, хортон мэрэгчгүй, гадны үнэргүй агуулахад хадгална.</li> <li>➤ Модон эсвэл хуванцар тавиур дээр хураана.</li> <li>➤ Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байх.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li> </ul>		

### 4."Цөцгийн тос"-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 4

№	Бүтээгдэхүүний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Цөцгийн тос	MNS 6657:2017
<p align="center"><b>Стандартын шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Нэр төрөлдөө тохирсон, өвөрмөц үнэргүй, гадны ямар нэгэн амт үнэргүй байна.</li> <li>➤ Нэгэн жигд нягт, уян налархай, зүсэлтийн гадаргуу нь гялалзсан, хуурай бөгөөд усны ил дусалгүй байна.</li> <li>➤ Шинжилгээний бичиг, дүгнэлттэй байна.</li> <li>➤ Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.</li> <li>➤ Агаарын харьцангуй чийглэгтэй, цэвэр хуурай, энгийн гэрэлтүүлэгтэй, агааржуулалт сайтай, хортон мэрэгчгүй, гадны үнэргүй агуулахад хадгална.</li> <li>➤ Модон эсвэл хуванцар тавиур дээр хураана.</li> <li>➤ Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байх.</li> <li>➤ Цөцгийн тосыг “MNS 5684:2006, Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын шаардлага хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савлана.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS6648:2016 стандартыг хангасан байна.</li> <li>➤ Цөцгийн тосыг бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>➤ Картон хайрцаганд савласан тосыг -18-25<sup>0</sup>С хэмд 6 сар хүртэл, мөнгөлөг, пергамент цаасанд жижиглэн савласан тосыг -5-8<sup>0</sup>С хэмд 3 сар хүртэл хадгална.</li> </ul>		



### 5. "Элсэн чихэр"-т тавигдах техникийн ерөнхий шаардлага

Элсэн чихэр нь MNS CAC 212:2014 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлыг шинжилгээнд бүрэн хамруулсан байна. Мэдрэхүйн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 5

№	Үзүүлэлтийн нэр	Шаардлага MNS CAC 212:2014
1	Өнгө	Жигд нарийн ширхэгтэй, цагаан өнгөтэй, уусмал нь тунгалаг өнгөтэй байна.
2	Үнэр	Өөрийн төрлийн үнэртэй
3	Амт	Өөрийн төрлийн чихэрлэг амттай
4	Чанар	Уусалт сайн
5	Хэлбэр дүрс	Нэр төрөлдөө тохирсон хэлбэртэй байх
6	Эрдэс хольц	Гадны хольцгүй
<b>Стандартын шаардлага</b>		
<ul style="list-style-type: none"> <li>➤ Шинжилгээний бичигтэй байна.</li> <li>➤ Чийггүй, бөөгнөрч хатуураагүй, шарлаагүй байна.</li> <li>➤ Агаарын харьцангуй буюу 70%-ийн чийглэгтэй, цэвэр хуурай, хортон мэрэгчгүй, гадны үнэргүй агуулахад хадгална.</li> <li>➤ Модон эсвэл хуванцар тавиур дээр хураана.</li> <li>➤ Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байх.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li> </ul>		

### 6. "Төмс, хүнсний ногоо"-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 6

№	Төмс, хүнсний ногооны нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Сонгино	MNS 0260:1982
2	Төмс	MNS 258:2006
3	Байцаа	MNS 0255:2007
4	Лууван /шар/	MNS 0270:1982
5	Манжин	MNS 0271:1982
6	Сармис	MNS 0267:1973
7	Чинжүү	MNS 0279:1982
<b>Стандартын шаардлага</b>		
<ul style="list-style-type: none"> <li>➤ Гарал үүслийн гэрчилгээтэй стандартын шаардлага хангасан тухай Улсын байцаагчийн дүгнэлттэй байна.</li> <li>➤ Төмс, хүнсний ногоо нь өвчин, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр дүрстэй, эх орны хүнсний ногоо нийлүүлнэ.</li> <li>➤ Төмс, хүнсний ногоонуудыг "MNS 3529:1983 Эргэлтийн шуудай" стандартын шаардлага хангасан шуудай, торон уут, эсвэл нийлэг хальсан уутанд савлана.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li> <li>➤ Төмс, хүнсний ногоог норох, хөлдөх, бохирдохоос хамгаалж бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэн хадгалалтын горим хангасан нөхцөлд хадгална.</li> </ul>		

## 7."Будаа"-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 7

№	Бүтээгдэхүүний нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Хүүхдийн будаа	MNS0243-2003
2	Цагаан будаа	MNS ISO7301-2000
3	Шар будаа	MNS0533-1998
4	Хөц будаа	MNS4515-1997
5	Эрдэнэшиш	MNS18-1999
<b>Стандартын шаардлага</b>		
<ul style="list-style-type: none"> <li>➤ Гарал үүслийн бичигтэй байна.</li> <li>➤ Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байна.</li> <li>➤ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх.</li> <li>➤ Нэр төрөлтэй тохирсон, өнгө үзэмж сайтай, исгэлэн, гашуун, хөгц зэрэг бусад гадны амт үнэргүй, сайн чанартай байна.</li> <li>➤ Стандартын шаардлага хангасан уут, шуудайнд савлаж амсарыг битүүмжилсэн байх.</li> <li>➤ Сав баглаа боодол нь эрүүл ахуйн шаардлага хангасан, бүтээгдэхүүнийг гэмтээх гадны ямар нэгэн бодис, нөлөөнөөс хамгаалсан байх.</li> <li>➤ Цэвэр, хуурай, агааржуулалт сайтай, хортон шавьжаар бохирдоогүй, гадны үнэргүй агуулахад хадгална.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li> </ul>		

## 8."Ургамлын тос"-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Ургамлын тос MNS 125:1998 стандартыг хангасан эрүүл ахуй, аюулгүй байдлыг шинжилгээнд бүрэн хамруулсан байна. Мэдрэхүйн үзүүлэлт нь Доорх шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 8

№	Үзүүлэлтийн нэр	Шаардлага MNS 125:1998
1	Өнгө	Цайвар шар өнгөтэй, тунгалаг тундас үүсээгүй байх
2	Үнэр	Өөрийн өвөрмөц үнэртэй, гаж үнэргүй байх
3	Амт	Нэр төрөлдөө тохирсон амттай байх
5	Хадгалах хугацаа	Хэтрээгүй байна.
<b>Стандартын шаардлага</b>		
<ul style="list-style-type: none"> <li>➤ Гарал үүслийн бичигтэй байна.</li> <li>➤ Үйлдвэрлэгдсэн болон хадгалалтын хугацаа тодорхой заагдсан, хайрцаг сав нь бүрэн бүтэн, хонхойж хэмхрээгүй байна.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүн стандартад нийцсэн байх</li> <li>➤ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна.</li> <li>➤ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх.</li> <li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li> </ul>		

## 9."Өндөг"-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 9

№	Тахианы өндөг	Шаардлага MNS 0095:1977

### Стандартын шаардлага

- Сар бүр гарал үүслийн гэрчилгээтэй байна.
- Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний бичигтэй байна.
- Зөв хэлбэр дүрстэй, шохойлог бүрхүүл хэвийн, гэмтэлгүй, хагарч холцроогүй байна.
- Гадна тал нь бохирдоогүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- Стандартад нийцсэн сав баглаа боодол, савлагаатай байна.
- Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж, хадгална.

### 10."Жимс, жимсгэнэ"-д тавигдах техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 10

№	Жимс, жимсгэний нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Алим	MNS CAC 299-2014
2	Помидор	MNS 0264:2009
3	Чацаргана	MNS 0916:2011
	<b>Стандартын шаардлага</b> <ul style="list-style-type: none"><li>➤ Гарал үүслийн гэрчилгээтэй байна.</li><li>➤ Хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй, гүйцэт боловсорсон, зөөлөн эд нь нягт хатуу байна.</li><li>➤ Хортон шавьж, авгалдай илрээгүй байна.</li><li>➤ Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байна.</li><li>➤ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан, дүгнэлттэй байна.</li><li>➤ Ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, агаарын харьцангуй чийглэгтэй, цэвэр хуурай, агааржуулалт сайтай, хортон мэрэгчгүй, гадны үнэргүй агуулахад хадгална.</li><li>➤ Зориулалтын сав баглаа боодолтой, гадны гэмтэл, нөлөөнөөс хамгаалсан байх.</li><li>➤ Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 стандартыг хангасан байна.</li></ul>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хая:

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    1. Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарийн дагуу тендерт оролцогч саналаа боловсруулж ирүүлнэ.
    2. Дэлгүүрт тавигдах шаардлага:
      - Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний чиглэлээр ижил загварын мэдээллийн самбар, санал хүсэлтийн дэвтэр байршуулна.
      - Дэлгүүрт харилцагч банкны ПОС машин байршуулсан байна. \Төрийн банкны поссын машинтай байх\
      - Үйлчилгээний зай талбай тохирох хэмжээнд байх ба нэгэн зэрэг олон үйлчлүүлэгчидтэй ажиллах боломжтой байна. Дэлгүүрийн үйлчилгээний талбайн зураг, хэмжээг ирүүлэх.
      - Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх 10 нэр төрлийн бүтээгдэхүүн заавал байх шаардлагатай бөгөөд дээрх бүтээгдэхүүнүүд олон сонголттой байвал зохино.
      - 10 нэр төрлийн бараанаас гадна өөрийн хэрэгцээт өөр хүнсний хориглоогүй барааг сонгон авч болох бөгөөд согтууруулах, мансууруулах гэх мэт хүнсний бус барааг олгохгүй байх
      - Гэрээ байгуулж ажиллах дэлгүүрийн байршил үйлчилгээ хүртэгч иргэдэд ойр тухайн багт байрлалтай байх шаардлагатай бөгөөд хүнсний эрхийн бичгээр олголтын үед ачаалал даах чадвартай байвал зохино.
      - Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэнд зохиулсан хямд үнэтэй чанаргүй, барааны хадгалалт хамгаалалт болон тээвэрлэлтийн горим алдагдсан бус байвал зохино.
      - Барааны сав баглаа боодол бүрэн бүтэн байх
      - Талоноор олгогдож байгаа бараа нь тухайн зах зээлийн болон дэлгүүрийн тендерт оролцохоор санал ирүүлсэн үнэтэй ижил үнээр олгогдоно.
      - Зураг - Санал болгож буй барааны зургийг хавсаргаж болно. Өгөгдлийн дагуу оролцож буй багцад үнийн санал боловсруулсан.
3. Төлбөр (ГЕН – 7)
  - 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
4. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
  - 6.1. Алданги оногдуулах хувь: **0.5**

Алдангийн нийт дүн: **10**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт /гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*